



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/14

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Сумын төв талбайд усан оргилуур байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог зөвшилцсөнөөр дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | |
|---------------------------|--|
| Үнэлгээний хорооны дарга: | Ж.Батмөнх (Засаг даргын орлогч) |
| Нарийн бичгийн дарга: | З.Баасандалай (Нийгмийн бодлогын мэргэжилтэн) |
| Гишүүн: | Ц.Адъяа (1 дүгээр багийн иргэн) |
| Хөндлөнгийн төлөөлөл: | Д.Дархижав (1 дүгээр багийн иргэн) М.Ургамал (2-р багийн иргэн) |

2. “Сумын төв талбайд усан оргилуур байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 0030